



842

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1990 оны 5 дугаар
сарын 26-ны өдөр

дугаар 91

Улаанбаатар хот

Нийслэлийн авто тээврийн
удирдлага, зохион байгуулалт
тыг боловсронгуй болгох зарим
арга хэмжээний тухай

Нийслэлийн авто тээврийн удирдлагын шат памжлагыг чөөрүүлэх аппаратыг иомхоттох, үйлчилгээг хөдөлмөрчдөд ойртуулах зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Тээврийг удирдах газар, түүний Хяналт борлуулалтын контор, Автобусны комбинатын захиргааг 1990 оны 6 дугаар сарын I-нээр тасалбар болгон нэгтгэж хотын нутаг давсгарт ачаа ба зорчигч тээврийн үйлчилгээ, шатах тослож материалын ашиглалт зарцуулалтад хяналт тавих, авто замын хураамжийг төвлөрүүлэн зам барилга, засварын ажлыг санхүүжүүлэх зэрэг тээврийн нэгдсэн бодлого явуулах уурэг бүхий Улаанбаатар хотын Тээврийг удирдах газар болгон шинээр зохион байгуулсугай.

2. Тээврийг удирдах газрын түрмийг хавсралтын ёсоор баталсугай.

3. Тээврийг удирдах газрын удирдлагын бүрэлдэхүүнийг дарга нэг, тээвэр эрхэлсэн орлогч дарга нэг, эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн орлогч дарга нэгтэй байхаар тогтоосугай.

4. Тээврийг удирдах газрын аппаратын 1990-1995 онд тогтвортой мөрдөх сарын цалингийн санг 46,8 мянган төгрөгөөр баталсугай.

5. Автобусны комбинатыг татан буулгасантай холбогдуулан Автобусны I, II паркийг Автобусны I, 2 дугаар бааз, Техникийн үйлчилгээ засварын станцыг аж ахуйн тооцоотой байгууллага тус тус болгох, 1991 оны Нэгдүгээр сарын I-нээс хоорондоо аж ахуйн гэрээтэй ажиллахаар тогтоосугай.

6. Хурлын байгууллагын эрх, уургийг өргөтгэж байгаатай холбогдуулан хөллөх бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, сэлбэг материалын болон хөренгө оруулалтын бодлого, санхүүжилтын эх үүсвэрийн системийн хэмжээний асуудлыг хотын Тээврийг удирдах газар хариуцан гүйцэтгэж байхаар тогтоосугай.

7. Автобусны комбинатын захиргааны конторын барилгыг шинээр зохион байгуулагдсан Улаанбаатар хотын Тээврийг удирдах газарт эзэмшиүүлэхээр тогтоосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ТҮҮЦЭТТЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Signature] Л.ЭНЭБИШ

ХАРИУЧЛАГАТАЙ НАРИИН БИЧТИЙН
ДАРГА

[Signature] Д.АЛГИА